



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.03.13

№ 335

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

"ХӨДӨӨ АЖ АХУЙ-ХӨГЖЛИЙН  
ИРЭЭДҮЙ" ОНӨХХК-ИЙ ЗАХИРАЛ  
Э.МӨНХ-ОЧИР ТАНАА

Аудитын дүгнэлт хүргүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу танай байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүгнэлт төлбөрийн акт, албан шаардлагыг хүргүүлж байна.

Аудитаар нийт 1,681,563.6 мянган төгрөгийн 10 зөрчил илэрснээс хууль хяналтын байгууллагад шилжүүлэх 58,400.0 мянган төгрөгийн 1 зөрчил, 11,304.8 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 1,507,858.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 104,000.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж ажиллана уу.

Жич: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн "20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн хуулийн зохицуулалттай.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ

632502675



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.13 № 334

таний \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

“ХӨДӨӨ АЖ АХУЙ-ХӨГЖЛИЙН  
ИРЭЭДҮЙ” ОНӨХХК-ИЙ ЗАХИРАЛ  
Э.МӨНХ-ОЧИР ТАНАА

**Дүгнэлт өгөхөөс татгалзсан**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ий 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийхээр төлөвлөсөн.

“Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ий 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн ба өргөн тархсан гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд дүгнэлт өгөх хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй байна.

**Дүгнэлт өгөхөөс татгалзсан үндэслэл**

Тайлант онд цалингийн картаар албан хаагчдад 99.8 сая төгрөгийн цалинг тооцсон ч санхүүгийн тайланд мөнгөн гүйлгээгээр 86.3 сая төгрөгөөр бүртгэн 13.4 сая төгрөгийн зөрүүтэй, Нийгмийн даатгалын тайлангийн тулгалтаар 1, 4, 5, 6, 7, 8, 9 дүгээр саруудын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг эхний 6 сард 2.0 сая төгрөгөөр дутуу, 7, 8, 9 дүгээр сард 0.6 сая төгрөгөөр илүү тус тус зөрүүтэй тайлагнасан нийгмийн даатгалын газартай тооцоо нийлсэн актгүй.

2023 оны хөрөнгө оруулалтаар ирсэн Баяд үүлдрийн 51.7 сая төгрөгийн 250 тоо толгой хуц, 6.8 сая төгрөгийн 50 тоо толгойн эрчмийн хар ухна ишиг нийт 58.4 сая төгрөгийн 300 тоо толгой богийг 1 иргэнд түрээсийн гэрээгүйгээр өгч 2024 онд 258 тоо толгой бог үхсэн гэх боловч малын эмчийн дүгнэлтгүй.

Өмнөх онд худалдан борлуулсан аймгийн нөөцийн өвс тэжээлээс 10,493 боодол өвс, 54 тн тэжээлийг худалдан борлуулснаас АЗД-ын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/74 тоот захирамжаар 1 боодол өвснөөс 500 төгрөг, 1 тн тэжээлээс 70.0 мянган төгрөгийн орлогыг авах нөхцөлтэйгөөр худалдан борлуулсан үүнээс 10493 боодол өвсний 5.2 сая төгрөг, 54 тн тэжээлээс 3.8 сая төгрөг, нийт 9.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй.

Тайлант онд түрээсийн гэрээгээр 305 иргэн, 9 аж ахуйн нэгжид 1,482.8 сая төгрөгийн 1287 тоо толгойн бог, бод малыг түрээсийн гэрээгээр олгосон, аймгийн нөөцийн өвс тэжээлээс 10,493 боодол өвс, 54 тн тэжээлийг худалдан борлуулсан

632503660

9.0 сая төгрөг нийт 1,491.8 сая төгрөгийн авлагыг огт бүртгээгүй.

"ХААХИ" ОНӨХХК нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ Нягтлан бодох бүртгэлийн тухай 4 дүгээр зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн стандарт 4.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөн" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, 14.5, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, толилуулга, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ